

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/255-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	16-17
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МХЕГ	Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-15 № (99-2023)255-НА-СТА-ТМЗ

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.8 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 3.2 хувиар хэмнэсэн байна.

Өөрийн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 51.2 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн торгуулийн орлогыг аймгийн хүү торгуулийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын татан буулгах шийдвэр гарч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан дэд комиссыг байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сангийн хамт холбогдох байгууллагуудад шилжүүлж, эд хөрөнгө, архив, албан хэргийн материалыг хүлээн авсан байна.

018020021

Аудитын гол асуудал

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 74.5 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 23,906.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжид 31,404.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	165,703,455.80	71,814,003.35
33	АВЛАГА	799,400.00	821,121.67
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	122,742.00	144,463.67
335	Бусад авлага	676,658.00	676,658.00
3351	Байгууллагаас авах авлага	676,658.00	676,658.00
35	БАРАА МАТЕРИАЛ	164,904,055.80	70,992,881.68
351	Түүхий эд материал	21,912,062.49	23,993,066.92
35130	Эм боох материал	21,912,062.49	23,993,066.92
35300	Бэлэн бүтээгдэхүүн	606,350.53	137,310.97
354	Хангамжийн материал	142,385,642.78	46,862,503.79
35410	Бичиг хэргийн материал	7,598,760.00	897,220.00
35470	Бусад хангамжийн материал	124,167,441.78	45,965,283.79
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	225,624,777.09	180,462,710.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	225,624,777.09	180,462,710.69
392	Биет хөрөнгө	189,019,159.82	145,502,221.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	37,325,333.43	37,325,333.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,375,803.12	-28,494,569.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	248,418,399.85	248,418,399.85
39204	Хуримтлагдсан элэгдэл	-225,594,011.85	-234,290,211.47
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	482,821,937.16	509,729,410.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-357,299,690.07	-403,156,802.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,725,364.72	41,725,364.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,982,553.92	-36,901,406.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,743,752.84	18,743,752.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,763,569.22	-7,597,050.35
393	Биет бус хөрөнгө	36,605,617.27	34,960,489.27
39301	Програм хангамж	8,793,000.00	8,793,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,231,382.73	-7,876,510.73
39303	Бусад биет бус хөрөнгө	34,044,000.00	34,044,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	391,328,232.89	252,276,714.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	391,328,232.89	252,276,714.04
51	Засгийн газрын хувь оролцоо	391,328,232.89	252,276,714.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	451,495,666.98	451,495,666.98
51101	Өмч: - төрийн	451,495,666.98	451,495,666.98
512	Хуримтлагдсан үр дүн	-72,936,817.00	-211,988,335.85
51210	Өмнөх үеийн үр дүн	-183,510,977.25	-72,936,817.00
51220	Тайлант үеийн үр дүн	110,574,160.25	-139,051,518.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,769,382.91	12,769,382.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	391,328,232.89	252,276,714.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,274,451,043.50	1,160,129,123.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,775,389.50	54,765,023.64
120	Нийтлэг татварын бус орлого	182,775,389.50	54,765,023.64
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	181,445,229.50	54,695,023.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,594,300.00	30,173,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	160,850,929.50	24,521,823.64
120009	Бусад орлого	1,330,160.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,091,675,654.00	1,105,364,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,091,675,654.00	1,105,364,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	931,258,600.00	943,213,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	155,160,554.00	161,431,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,163,876,883.25	1,299,117,355.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,163,876,883.25	1,299,117,355.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,634,530.83	1,018,095,369.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	562,540,767.38	601,342,298.36
210101	Үндсэн цалин	397,651,329.26	434,574,778.65
210102	Нэмэгдэл цалин	144,258,381.24	105,125,479.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,007,000.03	24,525,566.72
210104	Урамшуулал	6,624,056.85	37,116,473.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,035,701.20	75,774,572.56
210201	Тэтгэврийн даатгал	52,054,736.52	52,107,863.71
210202	Тэтгэмжийн даатгал	5,791,824.28	6,130,336.95
210203	ҮОМШ өвчний даатгал	4,522,579.41	4,803,966.84
210204	Ажилгүйдлын даатгал	1,060,596.37	1,157,491.32
210205	Эрүүл мэндийн даатгал	10,605,964.62	11,574,913.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,549,014.00	55,554,274.00
210301	Гэрэл цахилгаан	9,852,243.00	6,482,120.00
210302	Түлш, халаалт	19,806,431.00	33,480,694.00
210303	Цэвэр, бохир ус	2,221,140.00	1,922,260.00
210304	Байрны түрээс	13,669,200.00	13,669,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,413,345.00	66,774,375.78
210401	Бичиг хэрэг	8,260,275.00	11,386,592.42
210402	Тээвэр шатахуун	28,475,000.00	34,225,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,242,260.00	8,172,220.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,342,210.00	12,896,963.36
2105	Нормативт зардал	10,254,916.85	12,883,197.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,574,366.85	10,963,197.37
210502	Хоол, Хүнс	1,680,550.00	1,920,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,404,504.91	75,896,380.97
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	32,689,950.91	64,524,230.97
210604	Урсгал засвар	30,714,554.00	11,372,150.00
2107	Томилот, зочны зардал	27,387,300.00	41,658,600.00
210702	Дотоод албан томилот	27,387,300.00	41,658,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,086,712.00	9,824,877.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000,850.00	6,239,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	295,650.00	322,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	487,100.00	487,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,462.00	819,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	49,707.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,235,050.00	1,775,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,962,269.49	78,386,793.36
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	1,108,200.00	5,531,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	45,854,069.49	72,855,493.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,242,352.42	281,021,986.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	63,884,998.42	34,287,927.41
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	63,884,998.42	34,287,927.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,997,100.00	58,449,759.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,697,100.00	23,906,759.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	34,543,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,699,700.00	30,173,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,699,700.00	30,173,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	152,660,554.00	158,111,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	152,660,554.00	158,111,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	110,574,160.25	-138,988,232.17
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	63,286.68
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	0.00	63,286.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-63,286.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	110,574,160.25	-139,051,518.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,124,413,516.00	1,135,607,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	951,852,900.00	973,456,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	951,852,900.00	973,456,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	951,852,900.00	973,386,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	951,852,900.00	973,386,200.00
120009	Бусад орлого	0.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	172,560,616.00	162,151,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,560,616.00	162,151,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,143,562.00	720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	155,160,554.00	161,431,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,112,269,954.00	1,135,607,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,103,027,654.00	1,132,073,110.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	834,785,301.58	851,051,123.59
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	561,210,610.38	601,364,020.03
210101	Үндсэн цалин	397,651,392.26	434,596,500.32

210102	Нэмэгдэл	144,503,977.80	105,125,479.25
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	12,415,232.85	24,525,566.72
210104	Урамшуулал	6,640,007.47	37,116,473.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,035,701.20	75,774,572.56
210201	Тэтгэврийн даатгал	52,054,736.52	52,107,863.71
210202	Тэтгэмжийн даатгал	5,791,824.28	6,130,336.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,522,579.41	4,803,966.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,060,596.37	1,157,491.32
210205	Эрүүл мэндийн даатгал	10,605,964.62	11,574,913.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,549,014.00	55,554,274.00
210301	Гэрэл, цахилгаан	9,852,243.00	6,482,120.00
210302	Түлш, халаалт	19,806,431.00	33,480,694.00
210303	Цэвэр, бохир ус	2,221,140.00	1,922,260.00
210304	Байрны түрээс	13,669,200.00	13,669,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,707,650.00	37,110,240.00
210401	Бичиг хэрэг	9,648,320.00	2,265,830.00
210402	Тээвэр, шатахуун	33,760,000.00	24,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,242,260.00	8,172,220.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,963,470.00	2,128,590.00
2105	Нормативт зардал	11,970,710.00	13,265,710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,635,710.00	10,900,710.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	1,920,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	135,000.00	445,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,675,054.00	12,268,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,960,500.00	896,000.00
210604	Урсгал засвар	30,714,554.00	11,372,150.00
2107	Томиллолт, зочны зардал	27,387,300.00	41,658,600.00
210702	Дотоод албан томиллолт	27,387,300.00	41,658,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,141,062.00	8,524,257.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000,850.00	6,239,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	295,650.00	322,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	487,100.00	487,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,462.00	819,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	49,707.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,289,400.00	474,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,108,200.00	5,531,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,108,200.00	2,031,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,242,352.42	281,021,986.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	63,884,998.42	34,287,927.41
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	63,884,998.42	34,287,927.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,997,100.00	58,449,759.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,697,100.00	23,906,759.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	34,543,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,699,700.00	30,173,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,699,700.00	30,173,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	152,660,554.00	158,111,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	152,660,554.00	158,111,100.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,242,300.00	3,534,190.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,242,300.00	3,534,190.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,242,300.00	3,534,190.00
223001	Бусад хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,242,300.00	3,534,190.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,242,300.00	-3,534,190.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН			

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	-183,510,977.25	280,754,072.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	-183,510,977.25	280,754,072.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	110,574,160.25	110,574,160.25
C08	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	-72,936,817.00	391,328,232.89
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	-72,936,817.00	391,328,232.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	-72,936,817.00	391,328,232.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-139,051,518.85	139,051,518.85
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	451,495,666.98	12,769,382.91	-211,988,335.85	252,276,714.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	943,213,000.00	913,035,072.59	30,177,927.41	96.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	943,213,000.00	913,035,072.59	30,177,927.41	96.80
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,114,200.00	854,585,313.59	28,528,886.41	96.77
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	624,638,900.00	601,364,020.03	23,274,879.97	96.27
210101	Үндсэн цалин	421,930,200.00	434,596,500.32	12,666,300.32	103.00
210102	Нэмэгдэл цалин	131,649,100.00	105,125,479.25	26,523,620.75	79.85
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	34,122,000.00	24,525,566.72	9,596,433.28	71.88
210104	Урамшуулал	36,937,600.00	37,116,473.74	-178,873.74	100.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,079,900.00	75,774,572.56	2,305,327.44	97.05
210201	Тэтгэврийн даатгал	53,094,300.00	52,107,863.71	986,436.29	98.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,246,400.00	6,130,336.95	116,063.05	98.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,997,100.00	4,803,966.84	193,133.16	96.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,249,300.00	1,157,491.32	91,808.68	92.65
210205	Эрүүл мэндийн даатгал	12,492,800.00	11,574,913.74	917,886.26	92.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,008,700.00	55,554,274.00	2,454,426.00	95.77
210301	Гэрэл, цахилгаан	7,853,100.00	6,482,120.00	1,370,980.00	82.54
210302	Түлш, халаалт	33,290,500.00	33,480,694.00	-190,194.00	100.57
210303	Цэвэр, бохир ус	3,195,900.00	1,922,260.00	1,273,640.00	60.15
210304	Байрны түрээс	13,669,200.00	13,669,200.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,229,900.00	37,110,240.00	119,660.00	99.68
210401	Бичиг хэрэг	2,274,200.00	2,265,830.00	8,370.00	99.63
210402	Тээвэр, шатахуун	24,456,400.00	24,450,000.00	6,400.00	99.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,106,600.00	8,172,220.00	-65,620.00	100.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,300.00	93,600.00	-4,300.00	104.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,303,400.00	2,128,590.00	174,810.00	92.41
2105	Нормативт зардал	13,430,000.00	13,265,710.00	164,290.00	98.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,912,100.00	10,900,710.00	11,390.00	99.90
210502	Хоол, хүнс	2,070,000.00	1,920,000.00	150,000.00	92.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	447,900.00	445,000.00	2,900.00	99.35

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,915,300.00	15,802,340.00	112,960.00	99.29
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,535,100.00	3,534,190.00	910.00	99.97
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	896,000.00	896,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	11,484,200.00	11,372,150.00	112,050.00	99.02
2107	Томилолт, зочны зардал	41,680,300.00	41,658,600.00	21,700.00	99.95
210702	Дотоод албан томилолт	41,680,300.00	41,658,600.00	21,700.00	99.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,599,900.00	8,524,257.00	75,643.00	99.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,282,600.00	6,239,800.00	42,800.00	99.32
210803	Даатгалын үйлчилгээ	322,100.00	322,050.00	50.00	99.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	517,600.00	487,100.00	30,500.00	94.11
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	819,000.00	819,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	52,000.00	49,707.00	2,293.00	95.59
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	474,600.00	474,600.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,531,300.00	5,531,300.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	2,031,300.00	2,031,300.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,098,800.00	58,449,759.00	1,649,041.00	97.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,098,800.00	58,449,759.00	1,649,041.00	97.26
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,555,500.00	23,906,759.00	1,648,741.00	93.55
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,543,300.00	34,543,000.00	300.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	943,213,000.00	943,213,000.00	0.00	100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	943,213,000.00	943,213,000.00	0.00	100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	943,213,000.00	943,213,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47.00	43.00	4.00	91.49
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	28.00	4.00	87.50
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	166,191,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,040,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,040,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,040,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,040,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	158,111,100.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	158,111,100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	162,151,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,151,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	161,431,100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Мэргэжлийн хяналтын газар/ нь "Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт хуулийг сахиулан хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.



Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн төлөв байдлын талаар олон нийтийг мэдээллээр хангах,
- Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах,
- Дотоод хяналтын соёл нэвтрүүлсэн байгууллагыг бэлтгэх,
- Лабораторийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн, биелэлт, үр дүнг тооцох,
- Үндэсний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээний биелэлтийг хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын татан буулгах шийдвэр гарсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн үйл ажиллагаанд МХЕГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг МХЕГ-аас 2016 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,051.5 мянган төгрөгөөр буюу 64.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	799.4	821.1	21.7
Бараа материал	164,904.00	70,992.80	-93,911.2
Үндсэн хөрөнгө	225,624.70	180,462.70	-45,162.0

Нийт хөрөнгө	391,328.10	252,276.60	139,051.50
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	391,328.10	252,276.60	139,051.50
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	391,328.10	252,276.60	139,051.50

2006 онд үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 799.4 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдэл нь тайлант онд үүсэн 21.7 мянган төгрөгийн цалингийн авлагаар нэмэгдэж 821.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 164,904.0 мянган төгрөг болж 93,911.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 47,545.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон МХЕГ-аас 299.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 141,755.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 898,779.3 мянган төгрөг болж 26,907.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3,534.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 24,258.3 мянган төгрөгийн агаарын бохирдол хэмжигч, шатаах зуухыг МХЕГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан болон орон нутгийн төсвөөр бэлтгэгдсэн 885.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн ИТХ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 252,276.6 мянган төгрөг болж 139,051.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,307,943.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 406,610.7 мянган төгрөгөөр бууруулж /Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 278,138.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 106,301.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 8,184.5 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./ 901,332.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 41,880.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Хангамж, бараа материалын зардлыг 13,303.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 9,400.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж,
- Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 31,243.3 мянган төгрөгөөр,
- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 26,158.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.



Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 943,213.0 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 943,213.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 913,035.1 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 30,177.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	878,831.60	850,345.50	28,486.10	96.76
2	Мэдээлэл, сурталчилгааны зардал	840.50	800.00	40.50	95.18
3	Лабораторийн итгэмжлэл	3,442.10	3,439.80	2.30	99.93
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	60,098.80	58,449.80	1,649.00	97.26
	Дүн	943,213.00	913,035.10	30,177.90	96.80

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130032401 тоот дансанд торгуулийн төлбөр 161,431.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас томилолтын зардалд 720.0 мянган төгрөг зэрэг нийт 162,151.1 мянган төгрөг төвлөрснөөс аймгийн хүү торгуулийн орлогын дансанд 158,111.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, томилолтын зардал болон үлдэгдэл торгуулийн орлого 4,040.0 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,163,876.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,638.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МХЕГ-аас “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах чиглэл”-ийг харьяа албадад өгч ажилласны дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Байгууллагын цахилгаан, цэвэр, бохир усны хэрэглээг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мэргэжлийн хяналтын газрын мэдээлбэл зохиох 20 төрлийн 167 мэдээллээс 164-г хугацаанд нь мэдээлсэн бол 12-р сард дараах 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Байгууллагын батлагдсан төсөв /бүтэн жилээр/
- Худалдан авах ажиллагааны тайлан /бүтэн жилээр/
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан, 24,956.8 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1				

Зөвлөмж	3	24,956.8	2	3,060.0	66.7
Нийт дүн	4	24,956.8	2	3,060.0	50.0

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь татан буугдсан болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,419.9 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 8,919.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 9,500.0 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүллээ.



5.1 Албан шаардлага

1.1 Илрүүлэлт: Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 8,919.9 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант оны 12 дугаар сард ажил гүйцэтгүүлэх гэрээ, сургалтын явцын тэмдэглэл, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн шийдвэр зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 9,500.0 мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна Үүнд:


- Сургалт явуулсныг нотлох анхан шатны баримтын бүрдэлгүйгээр улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 5,000.0 мянган төгрөг,
- Автомашины засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэхийг тогтоож, хэлэлцэж шийдвэрлээгүй буюу эвдрэл гэмтлийг нотолсон анхан шатны баримтын бүрдэлгүйгээр албан хэрэгцээнд ашиглаж буй Ланд 100 маркийн автомашины сэлбэг хэрэгслийн зардалд 3,990.0 мянган төгрөг, үйлчилгээний төлбөрт 510.0 мянган төгрөг буюу 4,500.0 мянган төгрөг.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан.	1	8,919.9			1	8,919.9						
Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх.	1	9,500.0					1	9,500.0				
Дүн	2	18,419.9			1	8,919.9	1	9,500.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								